

МОНГОЛЫН ШАШИН-ТӨРИЙН ТҮҮХ БИЧЛЭГ ДЭХ “ЖАЛХАНЗ СУДЛАЛ”

Г.МЯГМАРСҮРЭН - МУИС-ийн Шашин судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Жалханз хутагт, жалханз судлал, шашин-төр, түвд намтар, хутагт судлал.

Товч утга: Жалханз судлал, түүнд холбогдох сурвалж, баримтыг судлах, судалгааны эргэлтэд оруулах нь ганц Жалханз хутагтын бус үе үеийн Жалханзууд, цаашлаад олон хутагт хувилгаадын тухай, тэдгээрийн Монголын шашин-төрийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, хоосон буйг нээн илрүүлэхэд нэн чухал ач холбогдолтой ажгуу.

“Зарлигаар тогтоосон олон аймгийн хутагт, хувилгаан нарын шастар”-аас үзэхүл, Жалханзын хувилгаад Энэтхэгийн орноо долоо, Түвдийн орноо зургаа тодорсон байна. Чухамдаа Түвдийн Галдан хийдийн хорин тавдугаар ширээт Балжиржамцыг “Жалханз” хэмээн нэрлэх болсноос хойш түвдэд дахин нэг хувилсан хийгээд тэр нь Чойжиржамц болно. Түүний хойтод Засагт хан аймгийн нэгэн хошууны нэр хүнд бүхий түшмэдийн гэр бүлд төрсөн арав орчим насны хүүг Жалханзын хувилгаан мөн хэмээн Лувсанданзанжамц хэмээн нэрийдснээр Монгол газраа анхлан тодорсон түүхтэй. Түүнээс хойш Лувсанданзанбал, Ишгэлэг, Галсандамба-Яримпэл, Лувсанбалжирлхүндэв, Чоймболжалцан, Чойжилжалцан, Дамдинбазар гэх долоон дүр тодрон гарч хутагт сэнтийг нь залгамжилжээ.

Жалханзын судалгааг хийхэд тулгуур болгон ашиглах гурван түвд намтар одоогоор бидэнд мэдэгдэж байна. Түүний анхных нь, Вангай равжамба хэмээх Агваанлуvsан-Иштүвдэнгийн 1863 онд бичсэн “Шашныг ихэд гийгүүлэн үйлдэгч Жалханз их эрдэнэ богд Лувсанбалжирлхүндэвийн намтар, сайн хувьтны чихний шимийг авахуй хэмээгдэх оршивой”, хоёр дахь нь гавж Агваанлхасүрэнгийн 1928 онд туурвисан “Гэтэлгэгч лам Жалханз их эрдэнэ Лувсанданзанжалцандамдинбазарбалсамбуугийн нууц гурван гайхамшигтаас гарсан намтар, зуун дэлбээтийн цэцэрлэгээс хувь төдийг өгүүлэн үйлдсэн цагаан лянхуан баглаа сайн чуулганы үүдийг нээгч хэмээх оршивой”, гурав дахь намтар нь Авирмэд /Лувсанвагмид/-ийн 1970-аад онд бичсэн “Шашныг гийгүүлэгч их Жалханз гэгээний Монголын оронд дараалан залагдсан дүрүүдийн намтрыг товчлон хурааж зохиосон оршивой” хэмээх гурав болно.

Нэг дэх намтар нь V дүрийн хувилгааны намтар хийгээд уг намтрын эхэнд Энэтхэг, Түвдийн орноо тодорсон дүрүүдийг дурдсан байна. Түүнчлэн Монгол газраа тодорсон нэг, хоёр дугаар дүрийн тухайд мөн өгүүлсэн хийгээд гутгаар дүр Ишгэлэгийн тухайд дурдсан нь үгүй болно. Харин дөтгөөр дүрийн хувилгаан Галсандамба-Яримпилийн тухайд багагүйг өгүүлсний хойтод Балжирлхүндэв хутагтын намтрыг үргэлжлүүлэн бичсэн байна. Хоёр дахь намтар нь найм дугаар дүрийн хутагт Дамдинбазарын намтар бөгөөд уг намтрыг Авирмэд бээр монгол хэлнээ орчуулсан, орчуулга нь эхийн хамт Хөвсгөл аймгийн музейд, харин гурав дахь намтар нь академич Ц.Дамдинсүрэнгийн гэр музейд тус тус хадгалагдаж байна.

Жалханз судлалд холбогдох өөр нэгэн сурвалж бол Гандантэгчинлэн хийдийн ламтан Иштавхай (1902-1972)-н “Лам нарын сүмбүмийн гарчиг” хэмээх бүтээл юм. Уг номонд Өндөр Богд, Чин сүжигт номун хан Лувсанноровшэйрав, Ялгуусан хутагт Лувсансамдүв, Жалханз хутагтын хувилгаан Галсандамба-Яримпил, Балжирлхүндэв, Дамдинбазар зэрэг арав гаруй лам нарын товч

намтар, бүтээлийн жагсаалтыг түвдээр бичсэн бөгөөд уг бүтээл нь 1961 онд Энэтхэгт хэвлэгдсэн.¹³⁷

Томоохон хутагт хувилгаад, лам нарын намтрыг бүр амьд сэрүүн байх үеэс нь эхлэн бичиж байжээ. Тухайлахул, Өндөр богдын намтрыг түүний наран, саран мэт хоёр шавийн нэгэн Халхын зая бандида Лувсанпрэнлэй бээр эртнээс бичиж байсан бололтой. Өөрийн бичсэн “Жавзундамба Лувсандамбийжалцанбалсамбуугийн ердийн товч намтар” хэмээх бүтээлдээ: “...өөрийн мэдэхгүйг лавлан асуухул, миний мэдсэн нь бага хийгээд бусад олон мэргэдийн адилаар өгүүлэх зүйл бага болно, хэлснийг нэмэлгүйгээр бич¹³⁸... хэмээн өгүүлсэн гэж дурдсанаас харагдах.

Жалханз хутагтын эхний дүрүүдийн намтрыг амьд ахуй хийгээд, хожим бичиж үлдээсэн эсэх нь одоогоор бидэнд мэдэгдсэн, олдсон нь үгүй юм. Харин V дүрийн Жалханз хутагтын намтрыг насан хутаг үзүүлснээс нь хойш арван долоон жилийн дараагаар түүний ойрын шавь нарын аман мэдээ, тэмдэглэл сэлтэд үндэслэн засаг ноён Чойгончигдашийн хүсэлтээр бичүүлсэн тухайд уг намтрын төгсгөлд өгүүлжээ. VIII дүрийн Жалханз хутагтын намтрыг түүний ойрын шавь, шанзав Агваанлхасүрэн гэгээнтнийг таалал барьснаас хойш таван жилийн дараа зохиожээ.

Анхдугаар Жалханз хутагтын тухайд болбоос Өндөр Богдын олон намтруудад нэр өгүүлсэн байх агаад Богдын дотны шавь нарын нэгэн нь хэмээсэн ч буй. Тухайлахул, дээр дурдсан Зая гэгээний туурвисан намтарт:

Жүржэд хэмээх шороон гахай жил (1659) Өлзий хутагт Цагаан нуур хэмээх газар Халхын долоон хошуу чуулган чуулж, түүнд урин залав /Өндөр богдыг хэлж байна/. Тэр чуулганд гэгээн хутагт Жалханз ч морилон заларч хсёр ламтан уулзан соёрхов. Шашин, төрийн гол хэргийг зөвлөлдөн хэлэлцэв. Баруун хошууны хаанд хэргэм цол олгох тэргүүтэн бүгдийг мөнхүү Богдод айлтгахад сэтгэлдээ таалан болгоов. Чуулганы үеэр би ч /Зая хутагт/ хоёуланд нь бараа болсон билээ. Тэдгээр нь урьд хожидод газар газраас ирсэн мөргөлчид, лам, ноёд, хар, хувраг, дээд, доод бүгдэд дээдийн номын хүрдийг эргүүлж бишрэл, авралын замд одуулав¹³⁹ гэх. Мөн Өндөр Богдын өөр нэгэн намтарт: “Урван үйлдэгч” нэрт усан гахай жил (1659) Богдын хорин тавны сүүдэр зэрэгцэхэд Үйзэт /Өлзийт/ цагаан нуур хэмээхүйд халх долоон хошуу ч чуулган чуулж, Богд ямагтыг урин залах чуулганд Хүдэнгийн хувилгаан ширээт Балжиржамцын гэгээн дүр жалханз хутагт Лувсанданзан мөн хүрэлцэн ирснээс учран золгохын бүрдэл хайрлав¹⁴⁰ хэмээжээ.

Энэ нь, Жалханзын хувилгааныг нэлээд эртнээс өөрийн нь биш ч Богд тэргүүтний намтраа дурдан өгүүлж иржээ. Хэд хэдэн намтарт цохон тэмдэглэсэн нь Халхын шашны тэргүүн Өндөр Богд, Засагт ханы нөлөө бүхий Жалханз гэгээнтэн нарыг ойрд нөхөрлөж асныг илтгэж байна.

V дүрийн намтар зохиогдон гарсан нь Жалханзын хувилгааны шашин-төрийн үйл хэргийг таньж мэдэх, судлах, судалгааны эргэлтэд оруулах бололцоог бидний үед үлдээсэн байна. Түүнчлэн дараа дараагийн дүрүүдийн намтар зохиогдон гарахын угтал болжээ. Эл намтрын мэдээгээр Оросын (хуучнаар Зөвлөлтийн) эрдэмтэн В.Л.Успенский “Жалханз хутагтын намтрын

¹³⁷ Бямбаа Р, Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл, /Боть I/ УБ., 2004, -Удиртгал хэсэгт [Yes shes thabs mkhas entitled. Bla ma dam pa rnam kyi gsung 'bum kyi dkar chag gnyen 'bral dran gso'i me long. New Delhi. 1961., Sata pitaka series. Vol616]

¹³⁸ Бира Ш, Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа III, УБ., 2001, 117 дахь тал

¹³⁹ Мөн тэнд, 119-120 дахь тал

¹⁴⁰ Агваандондов Сорхон, Түгээмлийн эзэн, номын итгэлт Богд тойн Лувсандамбийжалцанбалсамбуугийн сонин явдал хувь төгөлдөр “Тонилгохыг хүсэгчийн эгээрлийг хангахуй баясгалант хурим” нэрт оршивой. УБ., 1995, 37 дахь тал

баримт” хэмээх нэгэн өгүүллийг бичиж, тэр үеийн ЗСБНХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн “Монголын түүх соёлын судалгаа” хэмээх эрдэм шинжилгээний өгүүллийн эмхтгэлд хэвлүүлжээ.¹⁴¹ Агваанлуvsан-Иштүвдэн ламтны туурвисан дээрхи намтарт:

Жалханзын хувилгаан Балжирлхүндэв (1796-1846) бээр IV, V Богд Жавзундамба хутагттай ихэд ойр нөхөрлөж асан нь харагддаг. Тухайлахул, “...Жалханз хутагтын хойд дүр мөн хэмээгдэж хутагт сэнтийд заларсны дараа жилээ халх Богд /Лувсантүвдэнванчүгжигмэд (1775-1813)/-од бараалхан гэнэн сахил хүртэв. Богд хутагтад Лувсанбалжирлхүндэв хэмээх нэрийг соёрхов. Цагаагчин хонин жил (1811) Халх долоон хошуугаар хурал чуулган хийсэнд Жалханз хутагт бээр халх Богдод бараалхав. Энэ үед Гүмбүм хийдээс ирсэн Ажаа хутагт ринбүчи Лувсанжамъянжамц, Жанлам бандид Агваанлуvsандамбийжан, Лавран Дашпил хийдийн ширээт Жамъянтүвдэнням нарын эрдэмт лам нараас ном ихийг сонссон байна. Хутагт бээр халх Богдод айлтгаж их хүрдэн Очирваанийн ван сонссон бөгөөд Богд Жалханз хутагтад зандан дамар өгөөд, “Миний номын үндсийг дэлгэрүүлж яв” хэмээн зарлиг буулгажээ. Түүнчлэн шинээр байгуулагдсан Гунгаачойлин дацанд суухыг ч зөвлөсөн байна... Хар бичин жил Шадавжанчивлингийн рашаанд халх Богдын хамтаар очсон бөгөөд Богдоос равжамба, гэцэлийн сахил хүртэв гэх...

Түүнчлэн хөхөгчин хонин жил (1835) халх Богд /Лувсанчүлтэмжигмэддамбий (1815-1841)/ Ванчин ринбүчи, Түвдийн мэргэдээс номын авшиг хүртэхээр түвдийн орноо явах гэж буйг сонсоод бараалхав. Түвд явахад нь хоёр хоногийн газар хамт яван үдэж өгөөд буцав. Цагаагчин хулгана жил (1840) халх Богдод Богд лам (Зонхава)-ын сүмбүмийн аман эш өгөв. Богд хариуд нь мөн лүн хайрлав. Шинээр байгуулагдсан Гандантэгчинлэнд халх Богд олон хуврагуудад Жалханз гэгээнтнээс сонссон номоороо лүн талбив. Түүнд нь Жалханз хутагт байсан хийгээд Богд гэгээнтний гавьяа, тус ихийг ерөөсөн¹⁴² гэжээ. Энэ нь нэг талаас Жалханз хутагтыг бурханы номд гүнзгий нэвтэрснийг, нөгөө талаас халх Богдын ойрын нөхөр, хамтран зүтгэгч байсныг илтгэх аж. Түүнчлэн халх Богдтой шашин-төрийн чухал чухал үйл хэргийг ч зөвлөлдөж асан нь мөн намтраас харагдаж байна.

Цаашлахул, үе үеийн Монголын шашны тэргүүн Богд, Жалханзын хувилгаад номын багш шавийн барилдлагатай байсан хийгээд Монголын бурханы шашны төдийгүй төрийн чухаг чухаг асуудлыг хэлэлцэн, хамтын хүчээр шийдвэрлэн дагаж шийтгүүлдэг байж. Тодруулахул, Агваанлхасүрэн шанзавын туурвисан намтарт: “...Төмөр барс жил (1890) Гэгээн арван долоон настай, зуны дэлгэр цагаар Жавзундамбын VIII дүртэй уулзах хэргээр их хүрээг зорив. Богд Жавзундамба Гэгээнтэнд ихэд талархаж “Хамба номун хаан” цол магтаалыг хайрлаж хамбын зэрэг олгов. Усан луу жил (1892) Гэгээн арван есөн настай. Жалханз хутагтыг намрын нэгэн налгар өдөр Богд Жавзундамба дэргэдээ дуудан айлдан соёрхохдоо: Одоогийн хүнийг үзэхэд хайш яйш итгэмжгүй нь их байх юм. Ер нь хичээн хянах цаг болсон тул танд би шашин-төрийн хүнд үйл хэргийн үүргийг хүлээлгэхийн дээр бас өөрийн шадар (гүжир) хамбаар ажиллуулах гэж бодож байна. Түүгээр ч барахгүй одоо бид нар ямар зүг явахын хэмжээг нарийвчлан эс мэдэх тул миний санасан бүх хэргийг та л бүтээх хэрэгтэй... гэх зэргээр маш их учир шалтгааныг дотночилж нарийвчлан айлдав. Гэгээнтэн, Багшийн зарлигийг бүтээхээс илүү анхааран авалт үгүй, шашин

¹⁴¹ Хоёр их хутагт эмхтгэлд, 12 дахь тал

¹⁴² Ngag dbang blo bzang Ye she thub bstan, Bstan pa'i gsal byed chen po Rgyal khang rtze rin po che rje Blo bzang dpal 'byor lhun grub kyi rnam par thar bskal bzan rna ba'i bcud len zhes bya ba bzhugs so.

амьтны тусад буян үйлдэхээс илүү зүйл үгүй хэмээн зарлигийг шууд хүндлэн хүлээлээ. Ер нь одоогийн хутагтын шадар ойрхны хүмүүс сургууль соёлыг анхаарч хийдэггүй, хутагтын үйл хэргээр далимдуулан ном бус гэмт хэрэг үйлдэгчид олон. Эдгээр нь хувь хувиа бодож эд баялгийн шуналаар нэрвэгдэн баяр цэнгэлдээ ташууран буруу явдалд орсон байна. Ийм явдлыг мэргэд дээдсүүд шууд буруушаах нь зүй. Энэ нь Жалханз хутагтын гэгээн бодол болой...¹⁴³ хэмээжээ. Түүхийн ороо бусгаа эл цагт Жалханз хутагтад ихээхэн итгэлийг хүлээлгэсэн нь нэг талаас, түүний бурханы шавийн хувьд эзэмшсэн эрдэм мэдлэг, холч ухаанд найдсаных, нөгөө талаас, дээд дүрийн хутагтуудын багш, шавийн ойр дотно харилцаанд түшиглэх аваас ээдрээт асуудлыг шийдэхийн үүд ойр, дөт байсныг нотлох гэлтэй.

Найм дугаар дүрийн хутагт Дамдинбазарын тухайд, өөрийн намтраас гадна бичигдсэн ном зохиол нэлээд олон буй. Тухайлбаас: Дилав хутагт Жамсранжавын “Ар монголын улс төрийн дурдатгал”; Магсар хурцын “Монголын шинэ үеийн түүх”; Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид, “Монгол ардын үндэсний хувьсгал анх үүсч байгуулагдсан товч түүх”... гэхчлэн хамтран зүтгэгчдийн нь туурвисан бүтээл, мөн төрийн өндөр, хариуцлагатай албанаа зүтгэн буй үедээ өөрийн нь бичсэн ухуулга бичиг, захидал, бусад нөхдөөс нь ирсэн захидал гээд Жалханз хутагт Дамдинбазарт холбогдох сурвалж хэрэглэгдэхүүн архивт нэлээдгүй байна.

БНМАУ-ын түүх нэртэйгээр 1955 оноос анхлан хэвлэгдсэн монгол улсын түүхийн цувралуудад Жалханз хутагтын тухайд өгүүлсэн нь тун ховор юм. Учир нь лам, хувраг, шашны зүтгэлтнүүдийг ихээр хэлмэгдүүлсэн, шашнаар түрээ барин төрийн эрхэнд гарахаар завдагчид, шашныг хамаг амьтанд харштай хэмээх үзэл, онолд туйлшран байсных. Иймд хутагтын оролцсон хийгээд үйлдсэн гавьяаг төдийд дурдаагүй хэрэг. Заримд бусад нөхдийн нэрийн дор дурдсан байх боловч дэлгэрэнгүй, ойлгомжтой нь үгүй болно. Дурдагдсан нь, “...намын төв хороо, Ардын түр засгийн газраас тус орныг харийн ноёрхлоос чөлөөлөх тэмцэлд төрсөн орныхоо төлөө сэтгэл зовдог тийм феодалуудыг ч гэсэн татан оролцуулахын тулд их чармайж байсан юм. Ийм зорилгоор зохих захидал бичгүүдийг лам, ноёдод явуулж байв. Тийм захидлыг 3 дугаар сарын /1921 он/ 23-нд ерөнхий сайд Жалханз хутагтад явуулжээ¹⁴⁴ г.м...”

Харин 1990-ээд оноос хойш Монголын түүх бичлэгт шинэ урсгал гарч түүхэн үнэнийг тодотгон жинхэнэ эзэн биед нь холбогдуулан олон ургальч үзлийн үүднээс хандах болсон. Эл үеэс хойш гарсан түүхийн ном зохиолд нэр заан Жалханз хутагтын тухайд нэлээдгүй бичиж байна. Тухайлахул:

“1912 оны 8 дугаар сарын 7-нд Ховд хотыг бүрэн чөлөөлөхөд Жалханз хутагтыг оролцож үүрэг гүйцэтгэж байсныг /энэ тухайд, өмнө гарсан түүхийн ботиудад ерөөс Жалханз хутагтын нэрийг дурдаагүй болно/”; “1919 оны 7 дугаар сард хятад сайд Чен И-гийн шахалтанд автаж автономит эрхийг устгах тухайд Монголын эрх баригчид хуралдсан хийгээд Сэцэн хан, Жалханз хутагт Дамдинбазар нарын бүрэлдэхүүнтэй хэсэг төлөөлөгчдийг Бээжинд зарж, монголын автономит эрхийг устгахгүй байхыг Хятадын ерөнхийлөгчөөс

¹⁴³ Ngag dbang lha srung /Арваанлхасүрэн/, “Rje btzun bla ma Rgyal khang rtze rin po che Blo bzang bstan 'dzin rgyal mtsan rta mgrin bajra dpal bzang po'i gsang gsum rmad du byung ba'i nram par thar ba 'dab brgya'i dga' tsal las cha shas tzam gtam du byas pa pad dkar 'chun po legs tsogs sgo 'byed ces bya ba bzhugs so” (Гэтэлгэгч лам Жалханз их эрэднэ Лувсанданзанжалцандамдинбазарбалсамбуугийн нууц гурван гайхамшигтаас гарсан намтар, зуун дэлбээтийн цэцэрлэгээс хувь төдийг өгүүлэн үйлдсэн цагаан лянхуан баглаа сайн чуулганы үүдийг нээгч хэмээх оршивой). Цагаан лянхын баглаа сайн чуулганы хаалгыг нээгч, хэвлэлд Бат-Эрдэнэ Б, УБ., 1994, 9-11 дэх тал

¹⁴⁴ БНМАУ-ын түүх, УБ., 1984, 368 дахь тал

гуйлгахаар мордуулсан..."; "1919 оны орчимд хатанбаатар Магсаржав, жалханз хутагт Дамдинбазар, дилав хутагт Жамсранжав, да лам Пунцагдорж, гүн Гомбо-Идшин нарын үндэсний үзэлтэй, эх оронч зорилготой лам, ноёдоос бүрдсэн бүлэг үүсч байсан..."¹⁴⁵ гэхчлэнгийн олон зүйлүүдийг шинээр бичиж байна. Энэ нь Жалханз хутагтыг Монгол төрийн тусгаар тогтнол, үндэсний эв нэгдлийг хангахын тулд сэтгэл зовинон, түүнийг бэхжүүлэхийн төлөө идэвхийлэн зүтгэж асныг харуулж байна.

"Жалханз хутагт 1911, 1921 оны хувьсгалын хэрэгт онц хүчин зүтгэсэн, бас тодорхой нэгэн зурвас үед Засгийн газар тэргүүлж байсан төрийг тэтгэж, улсыг сахих туршлагатай зүтгэлтэн, төр засгийг номоор засах бичгийн хүмүүн тул лам, хар олны сэтгэлд ихэд нийцжээ... Жалханз хутагт, самади багш Дамдинбазар "Тулгар төрийг байгуулж, түвшнээр иргэнийг засаж, шашин, төрийг бататгаж, үнэн журмыг баримтална" хэмээсэн өөрийн үзэл санаа, амьдрал үйл ажиллагааныхаа хөтөлбөртөө чин үнэнч байж, улиран өнгөрч байгаа XX зууны эхэнд тохиосон үргэлжилсэн хоёр их хувьсгалын үйлсэд хоёргүй сэтгэлээр зүтгэсэн Монголын төрийн тулхтай зүтгэлтэн байсан юм"¹⁴⁶ хэмээн академич Ж.Болдбаатар судалгаандаа цохон тэмдэглэсэн байна.

Жалханз хутагтын судалгаанд холбогдох түвд болон түүхийн бусад сурвалжуудаас багахан зүйлийг тодруулан дурдахад Монголын шашин-төрийн түүхнээ гарсан олон чухал асуудалд эзэн бие холбогдох аж.

Үе үеийн Жалханз хутагтын дүрүүдээс илүүтэйгээр VIII дүрийн хутагт Дамдинбазар гэгээнтний судалгаа сүүлийн жилүүдэд багагүй хийгджээ. Ингэхдээ Монгол улсын ерөнхий сайдын үүрэгт ажлыг гүйцэтгэж асан шашин-төрийн томоохон зүтгэлтэн, түүхэн бие хүн болох талаас нь түлхүүд судалсан байна. Шашны төлөөлөгч, сахил хүртсэн санваартан, мяндагтан болохын хувиар нь судлах, зохиол бүтээл тэргүүтнээр нь дамжуулан гүн ухааны үзэл, онолыг шинжилсэн нь бага юм. Судалж, судалгааны бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нь академич Ж.Болдбаатар, доктор О.Батсайхан, Д.Дашбадрах, Б.Лааган, Л.Нямсүрэн, З.Лонжид, Г.Очирбат, О.Пүрэв, Л.Хүрэлбаатар¹⁴⁷ нарын зэрэг болно. Эдгээрээс Жалханз хутагтыг Монгол улсын ерөнхий сайдын албанаа хэрхэнд зүтгэн асныг Ж.Болдбаатар, О.Батсайхан нар судалсан байх агаад, төр улс төвхнөн эмхлэгдэж буй ээдрээт цагт төрийн чухал албыг алдагдуулалгүй залгуулж улс орны дотоод эв нэгдэл, нягтралыг чухлаа болгон буйг нь тодруулан гаргажээ. Харин Б.Лааган, Г.Нямсүрэн, Г.Очирбат, О.Пүрэв нар судалгаандаа хутагтыг XX зуунд гарсан хоёр томоохон хувьсгалд зорилго нэгэн нөхдийн хамтаар хэрхнээр оролцож, харийн халдан түрэмгийлэгчдийг үлдэн хөөж, ардын сэтгэлийг амаржуулан буйг нь голлон судалж, Д.Дашбадрах, Л.Хүрэлбаатар, З.Лонжид нар судалгаагаа хутагтын намтрыг тодруулах, бурханы номд идэвхийлэн суралцаж буй болон судалгаа

¹⁴⁵ Монгол улсын түүх, 5 дугаар боть, УБ.,2003. 62,86,105 дахь талууд

¹⁴⁶ Болдбаатар Ж, Монгол улсын засгийн газрын тэргүүн, УБ.,2003, 100-101 дэх тал

¹⁴⁷ Хоёр их хутагт, УБ.,1995-эмхтгэлд буй Батсайхан О., Лааган Б., Лонжид З., Очирбат Г., Пүрэв О., Хүрэлбаатар Л., нарын өгүүллүүд; Болдбаатар Ж., Монгол улсын засгийн газрын тэргүүн, УБ.,2003, 95-101 дэх тал; Дашбадрах Д., Монголын хутагтууд, УБ.,2004; Лааган Б., Жалханз хутагт Дамдинбазар, УБ.,1994,-Халхын тамга бүхий хутагтуудын товчис, УБ.,2004, 53-66 дахь тал; Нямсүрэн Л., "Общественно-политическая деятельность Жалханз хутагт Дамдинбазара (1874-1923) -Автореферат диссертации на соискание ученой степени доктора (Ph.D) по истории, УБ.,2005; Очирбат Г., Завхан аймгийн түүх (XVII-XX) УБ.,2003,- Хутагтууд бүлэг,- Жалханз хутагт Дамдинбазар 1911 оны Монголын үндэсний хувьсгалын удирдагчдийн нэг мөн,- Жалханз хутагт Дамдинбазарын багш шавийн барилдлага болон номын ёсыг сахихуй, Манай монгол сэтгүүл, УБ.,1999'04, 2005'01; Хүрэлбаатар Л., Огторгуйн цагаан гарьд, УБ.,1996,- Шимнусын омгийг очроор дарагч, 306-316 дахь тал.

хэрхнээр хийгдэж байгааг тодруулан өгүүлсэн гэх зэргээр ангилан зааглаж болох юм.

Монголын баруун хязгаараа нэр ихэд түгсэн Монголын шашин-төрийн томоохон төлөөлөгчдийн нэгэн Жалханз хутагт Дамдинбазар хийгээд түүний дээд дүүдүүд бүгдээр мөнд баруун зүгтээ тодрон гарч шашин амьтанд тус ихийг бүтээсэн нь Монгол түмний нэгдэл, шинэ тутам бүрэлдэж асан төрийн хэрэгт ач тусаа нэлээдгүй өгч байсан байна. Цаашлаад бурханы хувраг хүний ёсоор шашин юугаан цэвэр ариунаар мандуулах үзэл санааг эрхэмлэн аль чадахын хэрээр эш онолд улам улмаар шамдахыг ямагт бусдаа номлож, үлгэр үзүүлж байсан аж. Түүнчлэн Жалханз хутагтын хэд хэдэн дүр нь зохиол, бүтээл туурвисан болох нь намтар тэргүүтнээс харагдаж байна. Тэдгээрийг олон шинжилж, нээн гаргаваас Жалханз судлал дахь бас нэгэн талын хоосныг нөхөхийн учир буй.

Жалханз судлалд ихээхэн анхаарал татахуйц хэд хэдэн зүйл ажиглагддаг. Тухайлахул:

Ховдын Түгээмэл амаржуулагч сүм хийгээд Жалханз хутагтууд, Монголын шашны тэргүүн Богд Жавзундамба хийгээд Жалханз хутагтууд, Теократ төр хийгээд Жалханз хутагтууд, шашин юугаан цэвэр ариунаар мандуулах үзэл санаа хийгээд Жалханз хутагтууд гэх зэрэг болно. Эл бүгдийг хооронд нь харьцуулан судалбаас ихээхэн сонирхол татам судалгаа, үр гарах нь эргэлзээнгүй хэрэг болно.

Summary

Study of Jalkhanz hutagt is very important and interesting topic for Mongolian history. Therefore, we need more research work about each generation's Hutagts.

Jalkhanz hutagt was a high lamaist incarnation in Mongolia and played a high profile role in the Mongolian independence movement. If we'll do compared research work about all of Hutagts and Holiness of Mongolian King of Bogd Javzundamba's spiritual-political life history, that will be definitely necessary and interesting research work.

Ном зүй

1. Ngag dbang blo bzang Ye she thub bstan /Агваанлувсан-Иштүвдэн /, "Bstan pa'i gsal byed chen po Rgyal khang rtze rin po che rje Blo bzang dpal 'byor lhun grub kyi rnam par thar bskal bzan rna ba'i bcud len zhes bya ba bzhugs so" (Шашныг ихэд гийгүүлэн үйлдэгч Жалханз их эрдэнэ богд Лувсанбалжирлхүндэвийн намтар, сайн хувьтны чихний шимийг авахуй хэмээгдэх оршивой) /Түвд судар/
2. Ngag dbang lha srung /Агваанлхасүрэн/, "Rje btzun bla ma Rgyal khang rtze rin po che Blo bzang bstan 'dzin rgyal mtsan rta mgrin bajra dpal bzang po'i gsang gsum rmad du byung ba'i rnam par thar ba 'dab brgya'i dga' tsal las cha shas tzam gtam du byas pa pad dkar 'chun po legs tsogs sgo 'byed ces bya ba bzhugs so" (Гэтэлгэгч лам Жалханз их эрдэнэ Лувсанданзанжалцандамдинбазарбалсамбуугийн нууц гурван гайхамшигтаас гарсан намтар, зуун дэлбээтийн цэцэрлэгээс хувь төдийг өгүүлэн үйлдсэн цагаан лянхуан баглаа сайн чуулганы үүдийг нээгч хэмээх оршивой). Цагаан лянхын баглаа сайн чуулганы хаалгыг нээгч,-хэвлэлд Бат-Эрдэнэ Б., УБ.,1994
3. Агваандондов Сорхон., Түгээмлийн эзэн, номын итгэлт Богд тойн Лувсандамбийжалцанбалсамбуугийн сонин явдал хувь төгөлдөр "Тонилгохыг хүсэгчийн эгээрлийг хангахуй баясгалант хурим" нэрт оршивой. УБ.,1995 (түвд хэлнээс орчуулсан Д.Цэдэв)
4. Бира Ш., Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа III, УБ.,2001

5. БНМАУ-ын түүх, УБ.,1984
6. Болдбаатар Ж., Монгол улсын засгийн газрын тэргүүн, УБ.,2003
7. Бямбаа Р., Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл, /Боть I/ УБ.,2004
8. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг, УБ.,1995
9. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастар. Дэвтэр II, УБ.,1996
10. Монгол Улсын Түүх, боть V, УБ.,2003
11. Мягмарсүрэн Г., Самади багш, номун хан Жалханз хутагтын судалгаанд холбогдох зарим асуудал /бакалаврын дипломын ажил, удирдагч Очирбат Г./, УБ.,2005
12. Мягмарсүрэн Г., Жалханз хутагт Дамдинбазарын шашин, номын үйл ажиллагааны зарим асуудалд /Философи, шашин судлал-V, 263 (34)/, УБ.,2006
13. Очирбат Г.,нар. Завхан аймгийн түүх (XVII-XX зуун), УБ.,2003
14. Хоёр их хутагт эмхтгэл,-хэвлэлд Очирбат Г., Лувсанцэрэн Г., Чулуунбаатар В. нар, УБ.,1995
15. Хүрэлбаатар Л. Огторгуйн цагаан гарьд, УБ.,1996